



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/178

Хужирт сум

Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 40 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны “Зарим арга хэмжээг зохицуулах тухай” тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Сумын хэмжээнд бүх шатны төрийн байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод болон олныг хамарсан “Шинэ жилийн баяр”-ын үйл ажиллагааг тэмдэглэхийг хориглосугай.
- Коронавируст халдварт (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөвхөн гэр бүлийн хүрээнд “Шинэ жилийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхийг иргэдэд уриалсугай.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ